

АРДЧИЛСАН НАМЫН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ҮНДСЭН ДҮРЭМД НИЙЦҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Журмын зорилт

1.1.АН-ын дотоод зохион байгуулалтыг ҮД-д нийцүүлэх үйл ажиллагаатай холбогдон гарах намын байгууллага, сонгуульт гишүүдийг сонгох дотоод сонгуулийг энэ журмаар зохицуулна.

1.2.Намын ҮД-ийн шинэчилсэн найруулга Монгол Улсын Дээд Шүүхэд бүртгэгдсэнтэй холбогдон өмнө нь үйлчилж байсан намын ҮД, журмын зохицуулалтын зарим харилцаа буюу намын бүтцийн байгууллага, гишүүний эрх, үүргийг шилжилтийн үед хэрхэн хамгаалах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох зарчмыг энэ журмаар тодорхойлно.

2 дугаар зүйл.Журамд хэрэглэгдэх нэр томьёо

2.1.”зохион байгуулах зөвлөл”, “дэд зөвлөл” гэж зохих байгууллагуудын шийдвэрээр намын дотоод сонгууль зохион байгуулах, хянах зорилгоор байгуулах ажлын хэсгүүдийг;

2.2.“нэр дэвшигч” гэж өөрийн хүсэлтээр ҮД, энэ журмын шаардлагыг ханган, сонгуульт гишүүний сонгуульд нэр дэвшигчээр бүртгэгдэж, үнэмлэх авсан гишүүнийг;

2.3.“гишүүний татвар” гэж гишүүнээс нэг жилд намд төлөх мөнгөн хөрөнгийг;

2.4.“татварын баталгаа” гэж нэр дэвшигчээс сонгогдохыг хүссэн сонгуульт гишүүний татвартай тэнцүү дүнгээр намын дансанд урьдчилж байршуулсан мөнгөн хөрөнгийг;

2.5.“сонгуулийн зардал” гэж намын дотоод сонгууль явуулахад шаардагдах томилолт, бичиг хэргийн болон хурал хуралдуулах, сурталчилгаа, санал хураах үйл ажиллагааны зардлыг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ НАМЫН ДОТООД СОНГУУЛЬ

3 дугаар зүйл.Намын дотоод сонгуульд нэрээ дэвшүүлэх, бүртгэх

3.1.Намын дотоод сонгуульд “**нэр дэвшигч**” нь сахилгын шийтгэлгүй байхаас гадна ҮД-д заасан дараах нөхцөлийг хангасан байна:

3.1.1.намын Их хурлын төлөөлөгч, НАШБ-ын дарга, Тэргүүлэгч гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн сум, тосгон, баг, хорооны намын гишүүн байна.

3.1.2.сум, тосгоны намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн аймаг, дүүргийн харьяалалтай гишүүн байх ба зөвхөн нэг Сум, Тосгоны намын хорооны гишүүнд нэр дэвшинэ. Мөн тус аймгийн нутаг дэвсгэрт ажил эрхэлдэг гишүүн нь намын хорооны гишүүнээр ажиллах хүсэлтэй бол зохих баримт нотолгоог гарган нэр дэвшиж болно.

3.1.3.аймаг, дүүргийн намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд харьяалал харгалзахгүй ч зөвхөн нэг НДШБ-ын гишүүнд нэр дэвшинэ.

3.1.4.нийслэлийн намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд нийслэлд харьяалалтай байх бөгөөд аль ч дүүргээс нэр дэвшиж болно.

3.1.5.аймаг, дүүрэг, сум, тосгоны намын хорооны Тэргүүлэгч гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн намын хорооныхоо гишүүн байна.

3.1.6.аймаг, нийслэл, сум, дүүрэг, тосгоны намын хорооны дэд Даргад нэр дэвшигч нь тухайн намын хорооныхоо гишүүн байна.

3.1.7.аймаг, нийслэл, дүүргийн намын Даргад нэр дэвшигчийн хувьд тухайн шатныхаа намын хорооны гишүүнээр дөрөв (4)-өөс доошгүй жил ажилласан байна.

3.1.8.ҮБХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд харьяалал харгалзахгүй аль ч Аймаг, Дүүрэгт нэр дэвшиж болно.

3.1.9.ХЕХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигч нь ҮД-ийн 86.1-т заасан шаардлагыг хангасан байна.

3.1.10.УТЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн хувьд ҮБХ-ны гишүүн байна.

3.2.Намын дотоод сонгуульд нэрээ дэвшүүлэгч нь энэ журмын 3.1-д заасан сонгуульд гишүүнд нэр дэвших нөхцөл, шаардлага хангасан тухайгаа болон дараах холбогдох бичиг баримтыг үнэн зөв бүрдүүлнэ:

3.2.1.Намын хурлын байгууллагын гишүүн болон удирдах албан тушаалд нэр дэвшигчийн хувьд:

3.2.1.1.нэрээ дэвшүүлэх хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл;

3.2.1.2.тогтмол оршин суугаа газрын хаяг, иргэний үнэмлэхийн хуулбар;

3.2.1.3.хоёр хувь (3х4)-ийн хэмжээтэй зураг;

3.2.1.4.нийслэл, дунд шатны намын Даргад нэр дэвшигчийн хувьд тухайн шатныхаа намын хорооны гишүүнээр дөрөв (4)-н жил (*дөчин найм (48)-н сар*)-ээс дээш хугацаагаар сонгогдон ажиллаж байсан эсэх тухай нийслэл, НДШБ-ын ХЭГ-ын тодорхойлолт (*шаардлагатай тохиолдолд Нийслэлийн намын Даргын сонгуульд нэр дэвшигчийн хувьд ҮБХ-ны гишүүнээр дөрөв (4)-өөс доошгүй жил ажилласан тухай лавлагаа*);

3.2.1.5.гишүүний татвар, намын сонгуульт гишүүний татварын баталгааг намын дансанд байршуулсан санхүүгийн баримт;

3.2.1.6.сонгууль явуулах зардлын өөрт ногдох хувийг намын гишүүд, дэмжигчид, хувь хүн, хуулийн этгээдээс хуульд зааснаар бүрдүүлсэн тухай баримт;

3.2.1.7.бусад.

3.2.2.Хяналтын байгууллагын гишүүнд нэр дэвшигчийн хувьд энэ журмын 2-р бүлгийн 3.2.1.1-ээс 3.2.1.3-т заасан бичиг баримтаас гадна:

3.2.2.1.товч анкет (*бүртгэл эхлэх өдөр тавь (50)-н нас хүрсэн байх*);

3.2.2.2.намын гишүүний татвар төлснийг нотолсон ХЭЕГ-ын тодорхойлолт;

3.2.2.3.бакалаврын дипломын нотариатаар баталсан хуулбар;

3.2.2.4.намын төлөөллийн төв эсхүл хяналтын төв байгууллагын гишүүнээр найм (8)-н жил (*ерэн зургаа (96)-н сар*)-ээс дээш хугацаагаар сонгогдон ажиллаж байсан эсэх тухай намын хяналтын байгууллага, ХЭЕГ-ын тодорхойлолт (*ХсХ-ны гишүүний хувьд намын сонгуульт гишүүнээр найм (8)-н жилээс дээш хугацаагаар сонгогдон ажиллаж байсан эсэх*);

3.2.2.5.намын ҮД, журам зөрчиж, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй тухай **“Зохион байгуулах Зөвлөл”**-ийн лавлагаа (*намд элссэнээс*

хойш одоо үе хүртэл намын хяналтын байгууллагаас сахилгын шийтгэл хүлээж байсан эсэх);

3.2.2.6.авлига, албан тушаалын гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Цагдаагийн ерөнхий газрын лавлагаа (*намд элссэнээс хойш одоо үе хүртэл авлига, албан тушаалын гэмт хэргээр шүүхээс шийтгэл хүлээж байсан эсэх);*

3.3.Намын дотоод сонгуульд нэрээ дэвшүүлэгч нь энэ журмын 3.2-т заасан бичиг баримтаа дараах байгууллагад бүртгүүлэхээр мэдүүлнэ:

3.3.1.ҮБХ, ХЕХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд Намын төв байгууллагыг зохион байгуулах Дэд зөвлөлд;

3.3.2.аймаг, дүүргийн намын хорооны гишүүн, намын Даргын сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн шатны Дэд зөвлөлийн тав (5)-н гишүүнтэй бүрэлдэхүүнд;

3.3.3.сум, тосгоны намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн шатны Дэд зөвлөлийн гурваас тав (3-5)-н гишүүнтэй бүрэлдэхүүнд;

3.3.4.дүүргийн намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн хувьд тухайн шатны Дэд зөвлөлийн гурваас долоо (3-7)-н гишүүнтэй бүрэлдэхүүнд.

3.4.Дэд зөвлөлүүд нь нэрээ дэвшүүлэгчдийн бичиг баримтын бүрдүүлбэрийг хянан, шаардлага хангасан гэж үзвэл нэр дэвшигчээр баталж, түр үнэмлэх олгоно.

3.5.Дэд зөвлөл нь дараах нөхцөлд дотоод сонгуульд нэрээ дэвшүүлэгчийг бүртгэхгүй:

3.5.1.ҮД, энэ журамд заагдсан шаардлагыг хангаагүй, бичиг баримтаа гүйцэд бүрдүүлээгүй бол;

3.5.2.УИХ-ын 2024 оны сонгуульд намаас гарч бие даан болон өөр намаас нэр дэвшсэн, намын эсрэг ажилласан, хяналтын байгууллагаас шийтгэл хүлээсэн бол;

3.5.3.аймаг, нийслэл, дүүргийн 2024 оны ИТХ-ын сонгуульд АН олонх болоогүй, хамгийн олон санал аваагүй тохиолдолд тухайн шатны намын Дарга нь намын Дарга шинээр сонгох сонгуульд нэрээ дэвшүүлсэн бол.

4 дүгээр зүйл. Намын дотоод сонгуулийн ирц, гишүүний саналаа гаргах хэлбэр, аргачлал

4.1. Намын “**гишүүнчлэл, удирдлагын цахим бүртгэлд**” бүртгүүлэн, гишүүний татвараа тогтоосон хугацаанд төлж, гишүүний үнэмлэх буюу “**Ардчиллын гэрэгэ**” авснаар намын саналын эрхтэй гишүүнээр албан ёсоор тооцогдоно.

4.2. Намын байгууллагыг зохион байгуулж байгаа анхдугаар хуралдааныг хамгийн ахмад настай (*уг гишүүн өөрөө татгалзвал дараагийн ахмад настай*) гишүүн даргалан удирдаж, хуралдааны дарга, удирдлага сонгогдмогц эрхээ шилжүүлнэ. Хуралдааны дарга удирдлага нь хуралдааны тооллого, редакцын хэсэг, хэлэлцэх асуудлыг батлуулна.

4.3. Намын ҮД-д өөрөөр заагаагүй бол тухайн шатны намын хуралд саналын эрхтэй нийт гишүүдийн ердийн олонх оролцсоноор ирц хүчин төгөлдөр болно:

4.3.1. намын хурлын хуралдааны ирц нь хуралдаан дуустал хадгалагдана.

4.3.2. багийн бүх гишүүдийн хурлын хувьд ирц хүрээгүйн улмаас хурлаа дахин зарлан хуралдуулж болох бөгөөд хурлын ирцийн хувь нь нийт гишүүдийн дөч (40)-н хувь ба түүнээс дээш байна.

4.3.2.1. дахин зарласан намын үүрийн бүх гишүүдийн хурлын ирцийг бүрдүүлэх ажлыг тухайн болон дээд шатны намын байгууллагын удирдлага, Тэргүүлэгчид хариуцна.

4.4. Намын цахим бүртгэл (*шилжилт хөдөлгөөн хамаарна*)-д бүртгүүлсэн гишүүн зөвхөн харьяалагдах шатны намын байгууллагын хэмжээнд явагдах сонгуульд өөрийгөө гэрчлэх иргэний үнэмлэх болон “**Ардчиллын гэрэгэ**”-тэйгээр оролцоно.

4.5. Намын хуралдаанаар “**зохион байгуулалтын асуудал**”-аас бусад аливаа асуудлыг ил санал хураалт явуулж шийдвэрлэнэ.

4.6. Хууль, ҮД-д өөрөөр заагаагүй бол “**зохион байгуулалтын асуудал**”-ыг шийдвэрлэхдээ илт ойлгомжтой эсхүл өрсөлдөгчгүй тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн олонх зөвшөөрснөөр ил санал хураалт явуулж болно.

4.6.1.Санал хураалтыг илээр явуулах бол “дэмжинэ” гэсэн томьёоллоор гишүүн нэг бүрийг гар өргүүлэн тоолох бөгөөд хуралд ирсэн гишүүдийн олонхын санал аваагүй бол уг асуудлыг дэмжээгүйд тооцно.

4.7.Намын дотоод сонгуулийн нууц санал хураалт нь саналын хуудас дээрх “дэмжинэ”, “дэмжихгүй” гэсэн томьёоллын аль нэгийн өмнөх эсхүл өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг будаж, тэмдэглэх аргачлалаар явагдана.

4.7.1.энэ журамд өөрөөр заагаагүй бол саналын хуудас дээр хурлын тооллогын хэсгийн дарга гарын үсэг зуран, тухайн намын байгууллагын тэмдгийг дарж албажуулна.

4.8.Намын Их хурал, ҮБХ зэрэг олон төлөөлөлтэй хурлуудад цахим технологи ашиглан санал хураалт явуулж болно:

4.8.1.цахим санал хураалтад QR код ашиглаж болно.

4.8.2.гишүүн нь цахим төхөөрөмж дээрх “дэмжинэ”, “дэмжихгүй” гэсэн санал гаргах томьёоллын аль нэгний өмнөх эсхүл өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг товшин тэмдэглэх аргачлалаар саналаа гаргана.

4.9.Дотоод сонгуулийн дүн намын ҮД, журамд зааснаар нийт гишүүдийн болон сонгуульд оролцсон гишүүдийн ердийн олонхын, энэ журамд өөрөөр заагаагүй бол хамгийн олон саналаар гарна:

4.9.1.ХЕХ-ны хувьд хамгийн олон саналаар сонгогдох сонгуулийн дүнгийн хувь тухайн сонгуульд оролцох нийт гишүүдийн дөрөвний нэг (1/4) ба түүнээс дээш байна.

4.9.2.сонгуулийн дүнгийн хувь хүрээгүй тохиолдолд хамгийн олон санал авсан (*хоёр болон түүнээс дээш*) нэр дэвшигчдийг саналын хуудаст бичин, дахин санал хурааж шийдвэрлэнэ.

4.10.Нэр дэвшигч сонгогдоогүй тохиолдолд сонгуульт гишүүний татварын баталгааг нь буцаан олгоно.

4.11.Сонгуулийн санал хураалтын үеэр сурталчилгаа явуулахыг хориглоно.

5 дугаар зүйл.Дотоод сонгуулийн зардал

5.1.Намын дотоод сонгуулийн зардлыг холбогдох нэр дэвшигч болон түүнийг дэмжигч нар хариуцах бөгөөд нэр дэвшигчид нь ижил тэнцүү оролцоог баримтална:

5.1.1.дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардал;

5.1.2.дотоод сонгуультай холбоотой саналын болон бүртгэлийн хуудас, маягт олшруулах, бүх шатны ХЭГ-ын бичиг хэрэг, үйл ажиллагааны зардал;

5.1.3.намын хурлын зардал;

5.1.4.бусад.

5.2.Зардлын тооцоог НДШБ-ын ХЭГ-аас гарган, ХЭЕГ нэгтгэн ЗоБЗ-д оруулна.

5.2.1.ЗоБЗ-өөс зардлын дээд хязгаарыг тогтоож батална.

5.2.2.ХЭЕГ нь зарцуулалтад нь хяналт тавьж, тайланг нь хэлэлцэнэ.

5.3.Бүх шатны намын удирдлага, гишүүд нь намын дотоод сонгуульд нэр дэвшигчдээс хууль тогтоомжоор хориглосон мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ шаардахыг хориглоно.

6 дугаар зүйл.Сонгуулийн дүн гаргах, өргөн мэдүүлэх

6.1.Намын бүх шатны байгууллагын хурлын хуралдааны тооллогын хэсэг нь тухайн шатныхаа сонгуулийн дүнг тухай бүр шууд гаргана.

6.2.Дэд зөвлөл нь сонгуулийн санал хураалтын дүнг өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд нэгтгэн хорин дөрөв (24)-н цагийн дотор зохих байгууллагад нь мэдээлж, шийдвэрийн хуулбарыг цахим системд оруулна. Холбогдох материалыг ХЭЕГ-ын архивт далан хоёр (72) цагийн дотор хүргүүлнэ.

6.3.Дүнг хүлээн авсан байгууллага нь хорин дөрөв (24)-н цагийн дотор сонгуулийн дүнг нэгтгэх, шууд зарлахаар бол нийт гишүүдэд мэдээлэх, энэ талаар шийдвэр гаргах эсхүл зохих эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлнэ.

7 дугаар зүйл.Сонгууль ажиглах

7.1.Нэр дэвшигч нь дотоод сонгууль дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор сонгууль ажиглах этгээдийг ажиллуулах хүсэлт гаргаж болно

7.1.1.Сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг хөндлөнгөөс ажиглах этгээдийг “ажиглагч” гэнэ.

7.2.Нэр дэвшигч санал авах өдрөөс гурав (3)-аас доошгүй хоногийн өмнө ажиглагч бүртгүүлэх тухай хүсэлтээ Дэд зөвлөлд ирүүлэх ба хүсэлт ирсэн өдрөөс хойш хорин дөрөв (24)-н цагийн дотор ажиглагчийг бүртгэж,

үнэмлэх олгоно. Үнэмлэхийг нэр дэвшигч, түүний итгэмжилсэн хүнд олгож болно.

7.2.1.Бүртгэлд овог нэр, регистрийн дугаар, холбогдох утасны дугаарыг шаардана.

7.2.2.Ажиглагчийн үнэмлэхгүй хүнээр ажиглалт явуулахыг хориглоно.

7.2.3.Сонгуулийн дүн гарснаар ажиглагчийн бүрэн эрх дуусгавар болно.

7.3.Ажиглагчийн эрх үүргийг ЗоБЗ-өөс батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

8 дугаар зүйл.Байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн чиг үүрэг

8.1.Намын Дарга нь:

8.1.1.намын дотоод сонгууль явагдах хурлуудын товыг тогтооно.

8.1.2.намын шилжилтийн үйл явцыг удирдан зохион байгуулж, зарим шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлнэ.

8.2.Улс төрийн Зөвлөл нь:

8.2.1.ҮБХ-ны шинэ бүрэлдэхүүнийг сонгож, батлах хүртэл хугацаанд зохих шаардлагатай түр журам, тогтоол шийдвэрийг батална.

8.2.2.намын бүтэц, дотоод зохион байгуулалтыг ҮД-д нийцүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор **“Зохион байгуулах Зөвлөл”** (цаашид ЗоБЗ гэх)-ийг намын Даргын санал болгосон ес (9)-н гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

8.2.2.1.үйл ажиллагааны зардлын дээд хязгаарыг тогтоож батлах;

8.2.2.2.дэд зөвлөлүүдийг ерөнхий удирдлагаар хангах;

9 дүгээр зүйл.Зохион байгуулах Зөвлөлийн удирдлага, баримтлах зарчим

9.1.ЗоБЗ-ийг намын Дарга ахалж, нарийн бичгийн даргаар ЕНБД ажиллана.

9.2.ЗоБЗ нь дараах Дэд зөвлөлүүдийг байгуулж, үйл ажиллагаа, чиг үүргийг нь батална:

9.2.1.нутаг дэвсгэрийн намын байгууллага, тэдгээрийн удирдлагыг сонгох сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Дэд зөвлөл;

9.2.2.намын төв байгууллагуудын сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Дэд зөвлөл.

9.2.3.намын бүтэц, зохион байгуулалтыг ҮД-д нийцүүлэх дотоод сонгуулийн маргааныг хянан, шийдвэрлэх эрх үүрэг бүхий Дэд зөвлөл;

9.3.ЗoБЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх ба шийдвэрээ тогтоолоор гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, намын тэмдгийг дарна.

9.4.ЗoБЗ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь намын гишүүдийг хөндлөнгийн нөлөөгүйгээр нийтээрээ, шууд сонгох замаар саналаа чөлөөтэй гарган, намын дотоод бүтэц, сонгуульт гишүүдийг сонгох сонгуульд оролцох эрхийг хангах юм.

9.5.ЗoБЗ, Дэд зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаандаа ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх, энэ асуудалтай холбоотой шийдвэр гаргах санал хураалтад оролцохгүй байх зарчмыг баримтална.

10 дугаар зүйл.Зохион байгуулах Зөвлөлийн үйл ажиллагаа

10.1.ЗoБЗ нь дараах ажлыг зохион байгуулна:

10.1.1.энэ журамд өөрөөр заагаагүй бол намын дотоод сонгуулийн тов зарлах;

10.1.2.дэд зөвлөлүүдийн ажлыг уялдуулан, шууд удирдлагаар ханган ажиллах;

10.1.3.ХЭЕГ болон бүх шатны ХЭГ-ууд хамтран намын цахим бүртгэлийн санд саналын эрхтэйгээр бүртгэсэн гишүүдийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулах;

10.1.4.шинээр сонгогдсон аймаг, дүүргийн сонгуульт гишүүдийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулж хүргүүлэх;

10.1.5.сонгууль ажиглагчийн эрх үүргийг батлах;

10.1.6.дэд зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрөн ирүүлсэн гомдлыг хэлэлцэн, эцэслэн шийдвэрлэх.

10.2.ЗoБЗ нь Дэд зөвлөлүүдээр дамжуулан намын дотоод сонгуулийг ҮД, энэ журмын дагуу явуулах, ерөнхий удирдлагаар хангах үндсэн чиг үүргээс гадна дараах ажлыг хариуцна:

10.2.1.энэ журамд заасан сонгуулийн үйл ажиллагаа, хугацааны төлөвлөгөө батлах;

10.2.2.сонгуультай холбоотой дүрэм, журмыг таниулах;

10.2.3.сонгуулийн дүнг нэгтгэн гаргах, эрх бүхий байгууллагад мэдүүлэх;

10.2.4.хууль, дүрэм, журамд заасан шаардлага хангаж, зохих бичиг баримтаа бүрдүүлсэн нэрээ дэвшүүлэгчийг бүртгэх маягт, саналын хуудас болон нэр дэвшигч, ажиглагчийн үнэмлэх, хуралдаанд оруулах танилцуулгын загвар батлах.

10.3.ЗoБЗ-ийн санхүүгийн зарцуулалтыг зөвлөлийн хурлын шийдвэрээр ЕНБД хариуцна.

10.4.ЗoБЗ нь шинээр УТЗ байгуулагдсанаар татан буугдана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ

ЗОХИОН БАЙГУУЛАХ

11 дүгээр зүйл.Нутаг дэвсгэрийн намын байгууллагуудыг зохион байгуулах бүтэц, чиг үүрэг

11.1.ЗoБЗ нь нутаг дэвсгэрийн намын байгууллага, удирдлагыг сонгох сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий **“нутаг дэвсгэрийн намын байгууллагуудыг зохион байгуулах Дэд зөвлөл”**-ийг байгуулна:

11.1.1.ЗoБЗ-өөс аймаг, дүүрэг тус бүрт томилсон хоёр (2) гишүүн;

11.1.2.аймаг, дүүргийн намын хороо тус бүрийн Тэргүүлэгчдээс санал болгосон гурав (3)-н гишүүн;

11.1.3.сум, тосгоны намын хороо, Хорооны үүрийн Тэргүүлэгчдээс санал болгосон:

11.1.3.1сум, тосгоны намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчдийн төлөөллийг харгалзан багийн намын үүр тус бүрээс гурваас тав (3-5) хүртэл гишүүн;

11.1.3.2.дүүргийн намын хорооны гишүүний сонгуульд нэр дэвшигчдийн төлөөллийг харгалзан дүүргийн Хорооны үүр тус бүрээс гурваас долоо (3-7) хүртэл гишүүн.

11.2.Дэд зөвлөл нь нутаг дэвсгэрийн намын байгууллагыг зохион байгуулах хурал, тэдгээрийн хуралдаанаар явагдах сонгуулийг тухайн

шатны намын хороо, Тэргүүлэгчид, ХЭГ, намын хорооны хурлын хуралдааны удирдлага, тооллогын хэсэгтэй хамтран зохион байгуулна:

11.2.1.ЗoБЗ-өөс ирүүлсэн гишүүдийн нэрсийн жагсаалтыг нягтлан, аливаа сонгуулийг энэ жагсаалтын дагуу хугацаанд нь зохион байгуулж, санал хураалтын дүнг нэгтгэн, өргөн мэдүүлэх;

11.2.2.дотоод сонгуулийн зардлыг батлах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, ЗoБЗ-д тайлагнах;

11.2.3.хуралдаан явагдах байрны хаяг байршил, санал хураалтын өдрийн зарыг түгээсэн байдалд хяналт тавих;

11.2.4.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргэхэд хяналт тавих;

11.2.5.дотоод сонгуультай холбоотой аливаа маягт, үнэмлэх бусад бичиг баримтыг ЗoБЗ-өөс баталсан загварын дагуу хэвлүүлэн бэлтгэх ажлыг хариуцах бөгөөд энэ талаар нийт гишүүдэд таниулах;

11.2.6.сонгуульд нэр дэвшигчдийн лавлагааг хариуцах.

11.3.Хуралдааны дарга, удирдлага нь хурлаар явуулах сонгуулийг зохион байгуулж, шийдвэрийг батлуулна.

11.4.Тухайн шатны намын хороо, Тэргүүлэгчид, ХЭГ нь сонгуулийн ирц бүрдүүлэх, сонгуулийн бэлтгэл болон бусад ажлыг хангах, намын хурлын зарыг намын пэйж хуудас, сошиал, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэйгээр, хүн ам, худалдаа үйлчилгээ төвлөрсөн болон албан зар тавьж болохуйц газар олон нийтэд илээр цаасан зар наах зэргээр зарлах, харьяалагдах бүх гишүүдтэй холбогдон мэдэгдэх ба энэ талаар тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг зохион байгуулна.

11.5.Хуралдааны тооллогын хэсэг нь саналын дүнг гаргаж, хуралдааны удирдлагад мэдүүлнэ.

11.6.Аймаг, Нийслэл, Дүүргийн намын байгууллагын Даргын сонгуулийг шинээр сонгогдон байгуулагдсан намын хорооны хурлаас зохион байгуулна.

12 дугаар зүйл.Нийслэл, дунд, анхан шатны намын хорооны гишүүнийг сонгох сонгууль

12.1.Дэд зөвлөл нь АН-ын Даргаас товлон зарласан хугацаанд Сум, Тосгоны намын хорооны Тэргүүлэгчидтэй хамтран намын үүрийн бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, нууц санал хураалт явуулан, Сум, Тосгоны намын хорооны гишүүнийг сонгоно:

12.1.1.багийн намын үүрийн хурлаас сумын ИТХ-ын сонгуулийн мандатын тоог хоёр (2)-оор үржүүлсэнтэй тэнцэх хүртэл тооны гишүүдийг Сумын намын хорооны гишүүнээр;

12.1.2.тосгоны намын бүх гишүүдийн хурлаас Тосгоны намын хороог хорин нэг (21) хүртэл тооны гишүүнтэйгээр.

12.2.Дэд зөвлөл нь АН-ын Даргаас товлон зарласан хугацаанд Сум, Дүүргийн намын хорооны Тэргүүлэгчидтэй хамтран Сумын намын хороо, аймгийн төвийн баг, дүүргийн Хорооны үүрийнн бүх гишүүдийн хурлыг хуралдуулж, нууц санал хураалтаар Аймаг, Дүүргийн ИТХ-ын сонгуулийн мандатын тоог дөрөв (4)-өөр үржүүлсэнтэй тэнцүү тооны Аймаг, Дүүргийн намын хорооны гишүүнийг сонгоно.

12.2.1.аймаг, дүүргийн намын хорооны гишүүний сонгуулийн мандатын тоог ЗөБЗ-өөс тогтооно.

12.2.2.сум, тосгоны намын хороо, дүүргийн Хорооны үүрийн гишүүд:

12.2.2.1.энэ журмын 12.2-т заасан тоотой тэнцүү тухайн сум, хороонд ногдох аймаг, дүүргийн намын хорооны гишүүний суудлын тоогоор өөрийн сонгох нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг будаж тэмдэглэн, саналаа гаргана.

12.3.Дэд зөвлөл нь Дүүргийн намын хорооны Тэргүүлэгчидтэй хамтран Дүүргийн намын хорооны хурлыг хуралдуулан, харьяалагдах Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн мандатын тоог тав (5)-аар үржүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдийг Нийслэлийн намын хорооны гишүүнээр сонгох сонгуулийг явуулна.

12.3.1.Дүүргийн намын хорооны гишүүд:

12.3.1.1.энэ журмын 12.3-т заасан тоотой тэнцүү тухайн Дүүрэгт ногдох нийслэлийн намын хорооны гишүүний суудлын тоогоор өөрийн сонгох нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг будаж тэмдэглэн, саналаа гаргана.

13 дугаар зүйл.Аймаг, Дүүргийн намын хорооны Тэргүүлэгчдийн тоо

13.1.Аймаг, Дүүргийн намын хорооны Тэргүүлэгчдийн тоог дараах байдлаар тогтооно:

- 259.000-аас дээш хүн амтай дүүрэгт хорин нэг (21):
 - Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүрэг;
- 99000-259000 хүртэл хүн амтай аймаг, дүүрэгт арван ес (19):

- Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг, Хөвсгөл, Баян-Өлгий, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг;
- 89000-99000 хүртэл хүн амтай аймагт арван долоо (17):
 - Архангай, Төв, Ховд аймаг;
- 79000-89000 хүртэл хүн амтай аймагт арван тав (15):
 - Баянхонгор, Увс, Дорнод, Хэнтий аймаг;
- 69000-79000 хүртэл хүн амтай аймагт арван гурав (13):
 - Өмнөговь, Дорноговь, Завхан аймаг;
- 45000-69000 хүртэл хүн амтай аймагт арван нэг (11):
 - Булган, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар аймаг;
- 45000 хүртэл хүн амтай аймаг, дүүрэгт ес (9):
 - Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Говьсүмбэр аймаг.

14 дүгээр зүйл. Сум, Дүүрэг, Тосгон, Баг, Хорооны намын байгууллагыг зохион байгуулах

14.1. Дэд зөвлөл нь АН-ын Даргаас товлон зарласан хугацаанд энэ журмын 12.1-т заасан хурлаар сонгогдсон Сум, Дүүрэг, Тосгоны намын хорооны гишүүдийг хуралдуулан, тухайн шатны намын хороог байгуулж, нууц санал хураалтаар:

14.1.1. тухайн шатны намын Даргыг сонгох ба түүний саналаар:

14.1.1.1. намын хоёр (2) дэд Даргыг сонгоно.

14.1.1.2. сум, тосгоны хувьд намын гишүүдийн тоог харгалзан есөөс арван тав (9-15)-н гишүүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгч гишүүдийг сонгоно.

14.1.1.3. дүүргийн хувьд энэ журмын 13.1-д зааснаар есөөс хорин нэг (9-21)-н гишүүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгч гишүүдийг сонгоно.

14.1.2. сум, тосгоны намын Даргын тушаалаар сум, тосгоны намын зохион байгуулагчийг томилно.

14.1.3. дүүргийн намын ХЭГ-ын даргыг дүүргийн намын Даргын санал болгосноор намын хорооны Тэргүүлэгчдийн хурлаас баталж, ЕНБД-д санал болгоно.

14.2. Энэ журмын 14.1-д заасан хурал хуралдсан өдөрт багтаан Сум, Дүүргийн намын Даргын шийдвэрээр энэ журмын 12.1, 12.2-т заасан Сумын Баг, Дүүргийн Хорооны намын бүх гишүүдийн хурлыг хуралдуулж, намын

үүрүүдийг зохион байгуулан, дараах сонгуульт гишүүдийг нууц санал хураалтаар сонгоно:

14.2.1.сум, дүүргийн намын Даргаас дэвшүүлсэн намын үүрийн даргад нэр дэвшигч нь гишүүдийн ердийн олонхын санал авсан тохиолдолд намын үүрийн даргаар батлах;

14.2.2.үүрийн даргын саналаар намын гишүүдийн тоог харгалзан үүрийн таваас долоо (5-7)-н гишүүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгчдийг сонгох.

14.3.сум, тосгоны намын хорооны хурал, дүүргийн Хороо, Аймгийн төвийн болон арван мянга (10000)-аас дээш хүн амтай сумын багийн намын үүрийн хурлаас намын Их хурлын тус бүр нэг (1) төлөөлөгч сонгоно. *(Их хурлын төлөөлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь намын Их хуралд оролцох томилолтын зардлаа өөрөө хариуцахаа илэрхийлсэн байна.)*

15 дугаар зүйл.Аймаг, Нийслэлийн намын хороог зохион байгуулах

15.1.АН-ын Даргаас товлон зарласан хугацаанд энэ журмын 12.2, 12,3-т заасан хурлаас шинээр сонгогдсон Аймаг, Нийслэлийн намын хорооны гишүүд хуралдан, намын хороогоо байгуулж, тус хурлаас:

15.1.1.тухайн шатны намын Даргыг сонгох ба түүний саналаар:

15.1.1.1.намын хоёр (2) дэд Даргыг сонгоно.

15.1.1.2.аймгийн хувьд энэ журмын 13.1-д зааснаар есөөс хорин нэг (9-21)-н гишүүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгч гишүүдийг сонгоно.

15.1.1.3.нийслэлийн хувьд намын Дарга, дэд Дарга, ХЭГ-ын дарга, ИТХ-ын дарга, ИТХ дахь АН-ын бүлгийн дарга, Дүүргийн намын Дарга нар, намын харьяа байгууллагуудын дарга нараас бүрдсэн намын хорооны Тэргүүлэгчдийг батална.

15.1.2.ҮД-д заасан шаардлагыг хангасан гишүүд Аймаг, Нийслэлийн намын ХЭГ-т хандан Хяналтын салбар Хороо (ХсХ)-ны гишүүнээр сонгогдох хүсэлтээ гаргах бөгөөд ХЭГ нь тэдгээр нэр дэвшигчдийг намын хорооны хуралд танилцуулан, хэлэлцүүлж, нууц санал хураалт явуулан, хамгийн олон санал авсан долоо (7)-н гишүүнийг ХсХ-ны гишүүнээр сонгогдсонд тооцон ХЕХ-д өргөн мэдүүлнэ.

15.1.3.аймаг, нийслэлийн намын ХЭГ-ын даргыг аймаг, нийслэлийн намын Даргын санал болгосноор намын хорооны Тэргүүлэгчдийн хурлаас баталж, ЕНБД-д санал болгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ
ТӨВ БАЙГУУЛЛАГУУДЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ

16 дугаар зүйл.Намын төв байгууллагуудын сонгуулийг зохион байгуулах бүтэц, чиг үүрэг

16.1.ЗoБЗ нь намын төв байгууллагуудын сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий гишүүдээс бүрдсэн **“намын төв байгууллагуудыг зохион байгуулах Дэд зөвлөл”**-ийг ес (9)-н гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд уг Дэд зөвлөл нь Их хурлын төлөөлөгч, ҮБХ, ХЕХ-ны гишүүдийг сонгох сонгуулийг намын ХЭЕГ, НДШБ-тай хамтран зохион байгуулна:

16.1.1.дэд зөвлөл нь дараах үйл ажиллагааг явуулна:

16.1.1.1.ЗoБЗ-өөс ирүүлсэн Аймаг, Дүүргийн намын хорооны гишүүдийн нэрсийн жагсаалтыг нягтлан, сонгуулийг тус жагсаалтын дагуу хугацаанд нь зохион байгуулж, санал хураалтын дүнг нэгтгэж өргөн мэдүүлэх;

16.1.1.2.дотоод сонгуулийн зардлыг батлах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, УТЗ, намын хорооны Тэргүүлэгчдэд тайлагнах;

16.1.1.3.хуралдаан явагдах байрны хаяг байршил, санал хураалтын өдрийн зарыг түгээсэн байдалд хяналт тавих;

16.1.1.4.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргэхэд хяналт тавих;

16.1.1.5.дотоод сонгуультай холбоотой аливаа маягт, үнэмлэх бусад бичиг баримтыг ЗoБЗ-өөс баталсан загварын дагуу хэвлүүлэн бэлтгэх ажлыг хариуцах бөгөөд энэ талаар нийт гишүүдэд таниулах;

16.1.1.6.сонгуульд нэр дэвшигчдийн лавлагааг хариуцах.

16.1.1.7.энэ журмын 14.3-т заалтаар намын Их хурлын төлөөлөгчөөр сонгогдогсдийн нэрсийн жагсаалтыг Дэд зөвлөл хүлээн авч, ЗoБЗ-д хүргүүлнэ.

16.1.2.хуралдааны дарга, удирдлага нь хурлаар явуулах сонгуулийг зохион байгуулж, шийдвэрийг батлуулна.

16.1.3.ХЭЭГ болон НДШБ-ын Тэргүүлэгчид, ХЭГ нь сонгуулийн ирц бүрдүүлэх, сонгуулийн бэлтгэл болон бусад ажлыг хангах, намын хурлын зарыг намын пэйж хуудас, сошиал, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэйгээр зарлан, харьяалагдах бүх гишүүдтэй холбогдон заавал мэдэгдэх ба энэ талаар тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг зохион байгуулна.

16.1.4.хуралдааны тооллогын хэсэг нь саналын дүнг гаргаж, хуралдааны удирдлагад мэдүүлнэ.

17 дугаар зүйл.Намын төлөөллийн төв байгууллагыг сонгон байгуулах

17.1.Дэд зөвлөл нь намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний Бодлогын Хороо (ҮБХ)-ны гишүүнийг сонгох сонгуулийг намын Даргаас товлон зарласан хугацаанд бүх аймаг, дүүрэгт нэгэн зэрэг удирдан явуулна:

17.1.1.ҮБХ нь ҮД-ийн 75.3-т зааснаар нийт гурван зуун далан найман (378) гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүдийг Аймаг, Дүүргийн намын хорооны хурлаас нууц санал хураалтаар сонгож, намын Их хурлаар дөрвөн (4) жилийн хугацаагаар батламжилна. *(ҮБХ-ны шинэ бүрэлдэхүүн аймаг, дүүргийн намын хорооны хурлаас сонгогдсоноор өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болно.)*

17.1.1.1.ҮБХ-ны нийт бүрэлдэхүүний хувьд аль нэг хүйсийн төлөөллийг хуульд заасны дагуу баримтална.

17.1.2.ҮБХ-ны гишүүний суудлын тоог УИХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоо, тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бусад төлөөллийг тус тус харгалзан дараах байдлаар буюу хүснэгтэд зааснаар тогтооно.

17.1.3.ҮБХ-ны нийт гишүүдийн гурван зуун далан найм (378)-н суудлаас эмэгтэй гишүүдэд нэг зуун тавин хоёр (152) суудал ногдох бөгөөд дараах байдлаар хуваарилна. Үүнээс:

17.1.3.1.аймаг, дүүрэг тус бүрд ногдох эмэгтэй гишүүдийн суудлын нэг (1) суудал нь гучин ес (39)-өөс дээшгүй насны эмэгтэй гишүүдэд ногдоно.

17.1.3.2.эмэгтэй гишүүдийн суудлаас үлдсэн нэг зуун хорин хоёр (122) суудлыг аймаг, дүүрэг тус бүрд хуваарилна.

17.1.4.ҮБХ-ны нийт гишүүдийн гурван зуун далан найм (378)-н суудлаас эмэгтэй гишүүдийн зуун тавин хоёр (152) суудлыг хасаж, үлдсэн хоёр зуун хорин зургаа (226)-н суудлыг чөлөөт суудал гэх бөгөөд дараах байдлаар хуваарилна. Үүнээс:

17.1.4.1.аймаг, дүүрэг тус бүрд ногдох чөлөөт суудлын нэг (1) суудал нь гучин ес (39)-өөс дээшгүй насны эрэгтэй гишүүдэд ногдоно.

17.1.4.2.чөлөөт гишүүдийн суудлаас үлдсэн нэг зуун ерэн зургаа (196)-н суудлыг аймаг, дүүрэг тус бүрд хуваарилна.

Хүснэгт. АН-ын ҮБХ-ны гишүүний суудлын хуваарь.

№	Аймгийн нэр	Мандат	Нийт	Чөлөөт	Эмэгтэй	Залуу (эр 1, эм 1)
1	Баян-Өлгий	3	14	8	4	2
	Бовь-Алтай	10	10	5	3	2
	Бавхан		11	6	3	2
	Бвс		11	5	4	2
	Бовд		12	6	4	2
2	Брхангай	9	12	6	4	2
	Баянхонгор		11	5	4	2
	Бверхангай		13	7	4	2
	Булган	8	10	5	3	2
	Брхон		14	8	4	2
3	Бөвсгөл		14	8	4	2
	Бархан-Уул	10	14	8	4	2
	Бэлэнгэ		14	8	4	2
	Бөв		13	7	4	2
	Бовьсүмбэр	7	6	2	2	2
4	Борноговь		10	5	3	2
	Бундговь		10	5	3	2
	Бмнөговь		11	6	3	2
	Борнод	7	11	6	3	2
	Бүхбаатар		10	5	3	2
5	Бэнтий		11	6	3	2
	Баянзүрх	5	22	12	8	2
	Баянгол	3	19	10	7	2
	Бүхбаатар	6	19	10	7	2

	Ингэлтэй		19	10	7	2
1	Хонгинохайрхан	5	22	12	8	2
2	Хан-Уул	3	19	10	7	2
3	Багануур	2	6	2	2	2
	Багахангай		4	1	1	2
	Баянхонгор		6	2	2	2
	ИЙТ	78	378	196	122	60

17.2. Дэд зөвлөл нь дараах үйл ажиллагааг явуулна:

17.2.1. намын ҮБХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчдийг хугацаа тогтоон, зарлаж бүртгэлийг нь явуулна.

17.2.1.1. шаардлага ханган бүртгэгдсэн нэр дэвшигчдийн нэрсийг Аймаг, Дүүргийн ХЭГ-т албан журмаар мэдэгдэнэ.

17.2.2. аймаг, дүүргийн намын хорооны гишүүд, Их хурлын нийт төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг ЗөБЗ-өөс авч ХЭЕГ, Аймаг, Дүүргийн намын ХЭГ-тай хамтран тулгалт хийн нягтална.

17.2.3. ҮБХ-ны сонгуульд нэр дэвшигчдийг нэрсийг нь бүртгэгдсэн дарааллаар нь жагсааж, Дэд зөвлөлийн дарга гарын үсэг зуран, намын тэмдэг дарж албажуулсан саналын хуудсыг намын хорооны гишүүдийн тоо болон зохих нөөцтэйгөөр хэвлэн Аймаг, Дүүргийн намын ХЭГ-т хүргүүлнэ.

17.2.4. сонгуулийн сурталчилгааг зөвхөн Аймаг, Дүүргийн намын хорооны хуралдаан дээр явуулна. Ингэхдээ ҮБХ-ны гишүүнд нэр дэвшигчдийг Аймаг, Дүүргийн намын ХЭГ-аас танилцуулж, хэлэлцүүлэх бөгөөд намын хорооны гишүүд асуулт асууж, санал хэлж болно.

17.2.5. аймаг, дүүргийн намын хорооны гишүүн санал хураалтад оролцохдоо иргэний болон гишүүний үнэмлэх буюу “**Ардчиллын гэрэгэ**”-тэй байна.

17.2.6. аймаг, дүүргийн намын хорооны хурлаар явагдах нууц санал хураалтыг ҮД-д заасан квотын тоотой тэнцүү тооны тухайн Аймаг, Дүүрэгт ногдох чөлөөт болон залуучууд, эмэгтэйчүүдийн суудалд тус тус өөрийн сонгох нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг будан тэмдэглэж, саналаа гаргасан байхаар зохион байгуулна.

17.2.7. намын хорооны хурлын нууц санал хураалтын дүнгийн эрэмбээр нь нэр дэвшигчдийг жагсаан байрлуулж, хамгийн олон санал авсан

ҮД-д заасан тооны нэр дэвшигчдийг ҮБХ-ны гишүүнээр сонгогдсон тооцсон аймаг, дүүргийн намын хорооны хурлын тогтоолуудыг хүлээн авч нэгтгэнэ.

17.2.7.1.адил тооны санал авсан нэр дэвшигчид гарвал тухайн хоёр нэр дэвшигчийг саналын хуудсанд дахин бичиж, нууц санал хураалт явуулан шийдвэрлэнэ.

17.2.8.ҮБХ-ны гишүүнээр сонгогдсон гишүүдийг намын Их хуралд танилцуулна.

17.3.Их хурлын тооллогын хэсгийн зүгээс сонгуулийн санал хураалтыг цахимаар явуулна:

17.3.1.аймаг, дүүргээс сонгогдсон ҮБХ-ны гишүүдийн овог нэрсийг цахимд байршуулах бөгөөд нийт нэрсийн жагсаалтын өмнөх дэмжинэ эсхүл дэмжихгүй гэсэн сонголтын өмнөх дугуйн аль нэгийг нь Их хурлын төлөөлөгчид товшиж саналаа гаргана. *(сонгуулийг саналын хуудсаар явуулах болбол намын Их хурлын төлөөлөгч нь Их хурлын тооллогын хэсгийн дарга гарын үсэг зуран, тэмдэг дарж баталгаажсан саналын хуудас дээрх аймаг, дүүргээс сонгогдсон нийт ҮБХ-ны гишүүдийн овог нэрсийн өмнөх дэмжинэ эсхүл дэмжихгүй гэсэн дугуйн аль нэгийг нь будаж саналаа гаргана.)*

17.3.2.намын Их хурлын төлөөлөгчдөөс гаргасан саналын дүнг нэгтгэн, Их хурлын хуралдааны удирдлагад өргөн мэдүүлнэ.

17.4.Их хурлын хуралдааны дарга, удирдлага нь Их хурлын төлөөлөгчдийн ердийн олонхын санал авсан гишүүдийг ҮБХ-ны гишүүнээр дөрөв (4)-н жилийн бүрэн эрхтэйгээр батламжлах тогтоолыг танилцуулж Их хурлын төлөөлөгчдөөр батлуулна.

18 дугаар зүйл.Намын хяналтын төв байгууллагыг сонгон байгуулах

18.1.Дэд зөвлөл нь намын хяналтын төв байгууллага болохХяналтын Ерөнхий Хороо (ХЕХ)-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчдийг бүртгэн, сонгуулийг ҮД-д зааснаар намын Их хурлын хуралдаанаар удирдан явуулна:

18.1.1.ХЕХ-ны гишүүний сонгуульд нэрээ дэвшүүлэгчдийг энэ журмын 3.2.2-т заасан бүрдүүлбэрээ ирүүлсэн дарааллаар нь ҮБХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчидтэй хамт нэгэн зэрэг тогтоосон хугацаанд бүртгэнэ.

18.1.2.шаардлага хангасан нэр дэвшигчдийг бүртгэгдсэн дарааллаар нь ХЭЕГ-аас намын Их хуралд танилцуулна. ҮД-д зааснаар эрх

зүйч, санхүүгийн мэргэжилтэй, төрийн болон намын албан тушаал хашиж байсан нэр дэвшигчийн талаар онцлон дурдана.

18.2.Их хурлын тооллогын хэсгээс сонгуулийн санал хураалтыг цахимаар явуулна:

18.2.1.нэр дэвшигчдийг нэрсийг бүртгэгдсэн дарааллаар нь эрэгтэй, эмэгтэйгээр тусад нь цахимд байршуулах бөгөөд Их хурлын төлөөлөгчид сонгохыг хүссэн зөвхөн нэг (1) нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг товших аргачлалаар саналаа гаргана. *(сонгуулийг саналын хуудсаар явуулах болбол Дэд зөвлөлийн дарга гарын үсэг зуран, намын тэмдэг дарж баталгаажуулсан саналын хуудас дээр нэр дэвшигчдийг бүртгэгдсэн дарааллаар нь байршуулж, нууц санал хураалт явуулан, битүүмжилсэн хайрцгаар цуглуулж, намын Их хурлын төлөөлөгчдөөс гаргасан саналын дүнгээр нь нэр дэвшигчдийг эрэмбэлнэ.)*

18.2.2.эхний санал хураалтаар авсан саналаараа нийт санал хураалтад оролцсон төлөөлөгчдийн дөрөвний нэг (1/4) ба түүнээс дээш хувийн санал авсан гишүүдийг сонгогдсонд тооцно.

18.2.3.үлдсэн нэр дэвшигчдийн нэрсийг цахимд байршуулж, дахин санал хураалт явуулан, сонгуулийг санал хураалтад оролцсон төлөөлөгчдийн дөрөвний нэг (1/4) ба түүнээс дээш хувийн санал авсан эрэгтэй ес (9), эмэгтэй зургаа (6) буюу нийт арван тав (15)-н гишүүн бүрэн сонгогдох хүртэл үргэлжлүүлнэ.

18.2.4.намын Их хурлын төлөөлөгчдөөс гаргасан саналын дүнг нэгтгэн, хүйсийн төлөөллийг хуульд зааснаар баримтлан эрэмбэлж, Их хурлын хуралдааны дарга, удирдлагад өргөн мэдүүлнэ.

18.3.Их хурлын удирдлагын зүгээс хамгийн олон санал авч эрэмбэлэгдсэн арван тав (15)-н нэр дэвшигчийг намын ХЕХ-ны гишүүн *(анхны бүрэлдэхүүн)*-ээр баталсан тухай тогтоол батлуулна.

18.3.1.Их хурлын төлөөлөгчдөөс авсан саналаараа арван зургаа (16)-аас эхлэн эрэмбэлэгдсэн гишүүдийг ХЕХ-ны гишүүнээр нөхөн сонгогдох эрх бүхий гишүүнээр баталсан Их хурлын тогтоол гаргана. Нөхөн сонгуульд хүйсийн төлөөллийг баримтална.

18.4.ХЕХ-ны сонгогдсон гишүүд Их хурлын индрээс намын нийт гишүүдийн өмнө тангараг өргөснөөр бүрэн эрх нь хэрэгжиж эхэлнэ. Тангаргийн үгийг УТЗ-өөс батална.

19 дүгээр зүйл.Их хурлын зарим төлөөлөгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгох

19.1.ҮД-ийн 72.4-т заасан тоогоор Дүүргийн Хороо болон намын харьяа байгууллагаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдох Их хурлын төлөөлөгчийг энэ журамд заасан дүүргийн Хорооны бүх гишүүдийн хурал хуралдах үетэй давхцуулан дараах аргачлалаар сонгоно:

19.1.1.Их хурлын төлөөлөгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгох сонгуулийг Дэд зөвлөл, ХЭЕГ-аас зохион байгуулж, нийтэд ил тод зарлан явуулна:

19.1.1.1.нэрээ дэвшүүлэхээ илэрхийлсэн, намын нэгдсэн бүртгэл болон харьяалагдах шатны буюу нэр дэвшиж байгаа намын байгууллагадаа бүртгэлтэй, татвараа төлсөн гишүүдийг ҮД-ийн 72.4-т заасан байгууллагууд тус бүр бүртгэж, намын ХЭЕГ-т ирүүлнэ.

19.1.1.2.нэр дэвшигчдийн бүртгэлийг ХЭЕГ баталгаажуулж, баталгаажсан нэр дэвшигчдийн нэрсийг намын үүр, байгууллага тус бүрээр эхнээс нь дуустал дугаарлаж, санамсаргүй түүврээр сэлгэх огноог, харгалзах дугаарын хамт олон нийтэд нээлттэй ил, тод зарлана.

19.1.1.3.нэр дэвшигчдийн харгалзах дугааруудыг хавсралтад заасан блокчейн кодоор сэлгэн түүвэрлэж, ҮД-ийн 72.4-т заасан тоогоор эхнээс нь сонгоно.

19.1.1.4.санамсаргүй түүврийн аргын блокчейн кодыг нээлттэй платформ (*github*, *gitlab*) болон намын цахим хуудас дээр намын Их хурал хүртэл хугацаанд гишүүдэд нээлттэй ил, тод байршуулна.

19.1.1.5.Их хуралд төлөөлөгчөөр сонгогдсон гишүүдийн нэрсийг харгалзах дугаарын хамт ХЭЕГ-аас олон нийтэд нээлттэй, ил тод зарлана.

19.2.Түүврийн аргаар сонгох “блокчейн код” бүхий хавсралтыг УТЗ-өөс батална.

20 дугаар зүйл.Намын удирдах дээд байгууллагын төлөөлөл, бүрэн эрхийг нь батламжлах

20.1.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлын төлөөлөл нь томилогдох, сонгогдох зарчмаар бүрдэнэ.

20.1.1.намын Дарга, ҮБХ, ХЕХ-ны гишүүд, намын дэд Дарга, ЕНБД, Нийслэлийн намын Дарга, харьяа байгууллагуудын дарга нар их Хурлын төлөөлөгчдөөр шууд томилогдоно.

20.1.2.сум ба дүүргийн Хороо, аймгийн төвийн болон арван мянга (10000)-аас дээш хүн амтай сумын Баг, Тосгон тус бүрээс нэг (1) төлөөлөгч сонгогдоно.

20.1.3.нийслэлд дүүргийн Хороо тус бүрээс нэг (1), намын ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын байгууллага тус бүрээс арав (10), хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн байгууллага, оюутны байгууллага тус бүрээс зургаа (6)-н төлөөлөгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгоно.

20.2.Дэд зөвлөл нь намын Их хурлын нийт төлөөллийг дараах байдлаар албажуулан, намын Их хуралд өргөн мэдүүлж, бүрэн эрхийг нь батламжлуулна:

20.2.1.энэ журмын 14.3-т зааснаар сонгогдсон тухай намын үүр, хорооны хурлын тогтоолоор батлагдсан болон тэдгээрийг нэгтгэн НДШБ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталгаажсан төлөөлөгчид;

20.2.2.энэ журмын 17.1.1-д заасан хурлаас сонгогдон, Аймаг, Дүүргийн намын хорооны хурлын тогтоолоор тус тус батлагдаж, энэ журмын 17.4-т зааснаар Их хурлаас бүрэн эрх нь батламжлагдах ҮБХ-ны гишүүд;

20.2.3.энэ журмын 18.3-т зааснаар Их хурлаас сонгогдох ХЕХ-ны анхны бүрэлдэхүүн;

20.2.4.энэ журмын 19.1-д заасан санамсаргүй түүврийн аргаар сонгогдон, дүүргийн намын хорооны Тэргүүлэгчид болон харьяа байгууллагын тогтоолоор батлагдсан төлөөлөгчид;

20.2.5.энэ журмын 20.1.1-д заасан намын Дарга, намын дэд Дарга, ЕНБД, Нийслэлийн намын Дарга, харьяа байгууллагуудын дарга зэрэг намын Их хуралд томилогдох гишүүд.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

СОНГУУЛИЙН МАРГААН ХЯНАХ

21 дүгээр зүйл.Намын дотоод сонгуулийн маргаан хянах байгууллага, чиг үүрэг

21.1.ЗoБЗ нь ҮД-ийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдон явагдах намын дотоод сонгуулийн аливаа маргааныг хянах эрх үүрэг бүхий ес (9)-н гишүүнээс бүрдсэн **“дотоод сонгуулийн маргаан хянах Дэд зөвлөл”**-г байгуулах бөгөөд уг Дэд зөвлөл нь дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

21.1.1.намын дотоод сонгуулийн маргааныг яаралтай горимоор хянан үзэж, шийдвэрлэнэ.

21.1.2.ХЕХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчдийн сахилгын шийтгэл хүлээж байгаагүй тухай лавлагааг гаргах;

22 дугаар зүйл.Сонгуулийн хяналт

22.1.Намын дотоод сонгуулийн маргаан хянах Дэд зөвлөл нь сонгуулийн явцад намын ҮД, журам болон энэ журамд заагдсан сонгуультай холбоотой хориглосон заалтууд зөрчигдсөн тохиолдолд тухайн сонгууль зохион байгуулж байгаа байгууллага, сонгуульт албан тушаалтнууд, нэр дэвшигчид, албан ёсны ажиглагч болон гишүүдтэй холбоотой дараах дүгнэлтийг гаргаж шийдвэрлэнэ.

22.1.1.намын дотоод сонгуулийн үйл ажиллагаанд саад болсон, гишүүдийн саналд нөлөөлөх зорилгоор мөнгө, эд зүйлс тараах, амлалт өгсөн, сонгуулийн үеэр сурталчилгаа явуулсан тохиолдолд холбогдох этгээдийг нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасах;

22.1.2.намд гишүүнээр элсэх, бүртгүүлэх, мэдээлэл авах, намын дотоод сонгуулийн үйл ажиллагаанд оролцох болон гишүүний бусад эрхийг санаатайгаар зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан этгээдтэй холбогдох нэр дэвшигчийг нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасах;

22.1.3.ҮД сонгуулийн журам зөрчигдсөн, сонгуулийн байгууллага алдаа гаргасан, аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэл нь сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн бол уг сонгуулийг хүчингүй болгох;

22.1.4.ҮД, журам зөрчигдсөн, эсвэл тавигдах шаардлага хангаагүй нэр дэвшигч сонгогдсон тохиолдолд сонгуулийн дүнг хүчингүй болгож дараагийн санал авсан нэр дэвшигчийг батална.

22.1.5.дотоод сонгуулийн зохион байгуулалт, сонгуулийн явцын зөрчил нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлтэй бол дүгнэлтээ шинээр байгуулагдах хяналтын байгууллагуудад өргөн мэдүүлсэн байна.

22.2.Намын дотоод сонгуулийн маргаан хянах Дэд зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд ЗоБЗ руу гомдол гаргаж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД

23 дугаар зүйл.Зохион байгуулах зарим асуудал

23.1.ҮД ба энэ журамд заасан аливаа нэр, томьёо, хугацаа, сонгогдох гишүүдийн тоо, сонгох, сонгогдох зарчмыг намын дотоод сонгуульд ягштал баримтална.

23.2.Намын дотоод сонгуульд бэлтгэх ажлын хүрээнд намын Даргын шийдвэрээр:

23.2.1.намын **“нээлттэй цэгцтэй АН”** үндэсний аяныг зохион байгуулж, саналын эрхтэй намын гишүүдийн шинэчилсэн нэрсийн жагсаалт бүхий **“Гишүүнчлэл, удирдлагын цахим Бүртгэлийн сан”**-г бий болгох;

23.2.2.намын гишүүний үнэмлэх буюу **“Ардчиллын гэрэгэ”**-г батлан гаргаж, гишүүнчлэлийн аянаар бүртгэгдсэн гишүүдэд олгох;

23.2.3.нэн шаардлагатай журмууд боловсруулах **“Ажлын хэсэг”**-ийг байгуулах.

24 дүгээр зүйл.Бусад

24.1.ЗoБЗ, болон Дэд зөвлөлүүд, намын байгууллагууд нь намын дотоод зохион байгуулалтыг ҮД-д нийцүүлэх үйл ажиллагаатай холбоотой бүхий л бичиг баримт, материалыг намын ХЭЕГ-ын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө.

24.2.Намын хурал, сонгууль явагдаж буй газрын аюулгүй байдлыг хангах асуудлыг тухайн намын байгууллагын ХЭГ шийдвэрлэнэ.

24.3.Энэхүү журам батлагдмагц мөрдөгдөх бөгөөд журмаар зохицуулах зохион байгуулалт, үйл ажиллагаа дуусмагц хүчингүй болно.

---oOo---